УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД

2026 оны 07 дугаар сарын 27-ны өдөр Улаанбаатар хот

Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн №210/МА2026/014799 дугаартай магадлалд хяналтын журмаар гомдол гаргах нь

Энхрэй Кэйр ББСБ ХХК-ийн нэхэмжлэлтэй, Б.Уянга-д холбогдох Иргэний хэргийг хянан шийдвэрлэсэн Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн №210/МА2026/014799 дугаартай магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр гомдол гаргаж байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 172 дугаар зүйлийн 172.2.2, 172.2.3-д заасан үндэслэлээр энэхүү гомдлыг гаргав.

1. Хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн буюу Улсын дээд шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 001/ХТ2024/00101 дугаартай тогтоолоос өөрөөр тайлбарлаж хуулийг хэрэглэсэн тухайд:

Давж заалдах шатны шүүх нь зохицуулалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна. Тодруулбал Улсын дээд шүүхийн дээрх тогтоолоор зээлийн үүргийн хэмжээнд фидуцийн гэрээний дагуу шилжүүлсэн эд хөрөнгийг хариуцагчийн зээлийн гэрээний дагуу мөнгө төлөх үүрэгт тооцсоноор зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдаж, үүрэг дуусгавар болсон гэж дүгнэсэн нь Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.4 дэх хэсэгт заасанд нийцсэн гэж дүгнэсэн дүгнэлттэй үл нийцэж байна.

Өөрөөр хэлбэл Анхан болон давж заалдах шатны шүүх зохигчдын хооронд зээлийн гэрээний харилцаа үүссэн, гэрээ хүчин төгөлдөр гэж үзсэн нь Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1, 452 дугаар зүйлийн 452.1-д нийцсэн, түүнчлэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор барьцаа болон фидуцийн гэрээг байгуулсан нь хуулийн шаардлага хангасан. Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.4-д "Үүрэг хүлээгч мөнгө төлөх үүргээ хугацаанд нь биелүүлж, шилжүүлсэн эд хөрөнгөө буцаан авсан буюу ийнхүү үүргээ биелүүлээгүй бол өмчлөлд шилжүүлсэн эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгч бодитойгоор гаргуулан авснаар үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ дуусгавар болно" гэж заасан тул зээлдүүлэгч нь зээлдэгчийн эзэмшилд байсан фидуцийн гэрээний зүйл болох автомашиныг 2024 оны 09 сард хураан авсан.

Ийнхүү хураан авснаас хойш автомашиныг үүргийн гүйцэтгэлд оруулж тооцохгүй гэж огт мэдэгдээгүй, хариуцагч Б.Уянга өөрийн эзэмшиж байсан гар утасны дугаар хэвээрээ байсан нь Юнител ХХК-ийн гаргаж өгсөн тодорхойлолтоор нотлогддог. Эндээс үзвэл нэхэмжлэгч нар үүргийн гүйцэтгэлээс татгалзах, татгалзлаа

илэрхийлээгүй, түүнчлэн автомашиныг худалдан борлуулах замаар зээлийг хааж байгаа нь хүлээн авсныг нотлодог.

Гэтэл шүүхээс машин хураан авснаас хойш нэхэмжлэгч шүүхэд нэхэмжлэл гаргах хүртэл хугацааны хүүг төлүүлэх шийдвэр гаргаж байгаа нь илт нэг талд хэргийг хянан шийдвэрлэсэн болох нь харагдана. Өөрөөр хэлбэл зээлийн гэрээг талууд харилцан дуусгавар болгохоор зөвшилцөж, үүргийн гүйцэтгэлийг хариуцагч өөрөө сайн дураар хүлээлгэн өгсөн.

Хүлээн авснаас хойш боломжит хугацаанд нэхэмжлэгч татгалзал илэрхийлээгүй. Илэрхийлэх бүрэн боломжтой байсан. Үүнийгээ нотлоогүй. Аль 2024 оноос хойш 2026 он хүртэл хугацааны хүүг тооцуулж нэхэмжилсныг Давж заалдах шатны шүүх хангасан нь хууль хэрэглээний хувьд маш том алдаатай шийдвэр болсон.

Улсын дээд шүүхийн тогтоолоор эд хөрөнгийг шилжүүлэн авахад тухайн эд хөрөнгийн чанар муудсан, ашиглах боломжгүй болсон бол түүнийг хүлээн авахаас татгалзаж үүргийн гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр шаардах эрхээ хэрэгжүүлэх боломжтой талаар дурьдсан байдаг.

Тодруулбал тогтоолын “ХЯНАВАЛ” хэсгийн 20 дугаарт “Барьцаа”-ны хэлцэл болон “Фидуци”-ийн хэлцлийг ялган тайлбарлаж, дүгнэлт хийсэн.

Гэтэл Давж заалдах шатны шүүхээс “ФИДУЦИ”-ийн хэлцэл, “БАРЬЦАА”-ны хэлцлийг ялгахгүй, ялгааг тайлбарлахгүй, түүнд дүгнэлт хийлгүй шууд ФИДУЦИ бол БАРЬЦАА гэж шийдвэрлэж байгаа нь хуульд нийцэхгүй. Мөн магадлалын 7 дугаар нүүр, 7.5 дах хэсэгт маш сонирхолтой дүгнэлт хийснийг гайхаж байна. Үүнийг үзвэл Зээлийн гэрээний үүрэг тусдаа, Фидуцийн гэрээний үүрэг тус тусдаа, ялгаатай мэтээр тайлбарласан байна. Автомашиныг хураасан нь фидуцийн гэрээг дуусгавар болгосон харин зээл нь үлдсэн гэжээ.

Энэ бол Иргэний эрх зүйд байж боломгүй дүгнэлт тул санал нийлэхгүй. Өөрөөр хэлбэл Фидуцийн гэрээний үүрэг бол тусдаа үүрэг биш энэ бол Зээлийн гэрээний дагалдах хэлцэл буюу дагалдах (accessory) шинж чанартай эрх, үүрэгтэй хэлцэл юм. Энэ нь Зээлийн гэрээгүй фидуцийн хэлцэл гэж байхгүй. Харин Фидуцийн гэрээгүй зээлийн хэлцэл байж болно гэсэн гол санаа мөн. Иймд Иргэний хуулийн 235 дугаар зүйлийн 235.4-г буруу тайлбарлаж, дагалдах үүрэг дууссан, үндсэн үүрэг үлдэж тусдаа гэх агуулгаар тайлбар хийж болохгүй. Тэр тусмаа фидуцийн гэрээний хувьд ийм тайлбар хийх нь зохимжгүй бөгөөд тэгвэл хууль тогтоогчийн зүгээс тусгайлан фидуцийн гэрээг хуульчлах шаардлагагүй. Бүх харилцааг зөвхөн барьцааны хэлцлийн зохицуулалтаар шийдвэрлэх нь зохимжтой.

Нөгөө талаар хэрэв нэхэмжлэгч Фидуцийн гэрээний дагуу үүргийн гүйцэтгэл буюу автомашиныг хүлээн авахаас татгалзсан бол хариуцагч нар нь өөрсдөө автомашинаа авахад татгалзахгүй байсан.

2. Шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн буюу хариуцагчид мэтгэлцэж, тайлбар хэлэх боломжийг олгоогүй тухайд:

Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар давж заалдах журмаар гаргасан гомдолдоо шүүхэд тайлбар гаргах, шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжийг шүүхээс олгоогүй хэргийг шийдсэн агуулгаар гомдол гаргасан.

Иймхүү Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүх хуралдаанд нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар гомдлоо, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь гомдлын үндэслэлд тайлбар хэлэх боломжийг тус тус олгосон юм.

Харин Давж заалдах шатны шүүх гомдлын хүрээнээс гадуур хэргийг хянан шийдвэрлэхдээ хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч тайлбар хэлэх, няцаалт хийх ямар ч боломжийг олгоогүй хэргийг хянан шийдвэрлэж байгаа нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан “МЭТГЭЛЦЭХ ЗАРЧИМ”-ыг хангаагүйн шууд илрэл болно.

Өөрөөр хэлбэл Давж заалдах шатны шүүхэд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч зээлийн үүрэг, өнөөдрийг хүртэл тооцсон хүүтэй холбоотой маргах, мэтгэлцэх, тайлбар няцаалт хийх боломж огт олгоогүй.

Иймд дээрх үндэслэлүүдээр Давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээх эсхүл хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэж өгнө үү.

ГОМДОЛ ГАРГАСАН: **ХАРИУЦАГЧИЙН ИТГЭМЖЛЭГДСЭН ТӨЛӨӨЛӨГЧ М.ЖАВХЛАН**